



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 61

Ховд

“Чадварлаг багш, оюутан, сурагч”  
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.24 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Багш, оюутан, сурагчдыг дэмжих, урамшуулах, хөгжүүлэх замаар нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд чиглэгдсэн “Чадварлаг багш, оюутан, сурагч” дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулан “Чадварлаг багш нарыг дэмжих, урамшуулах журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховдын ирээдүй” тэтгэлэг олгох журмыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хөтөлбөр болон журмуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

4.Хөтөлбөр, журмуудын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дүнг жил бүр аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г. ПҮРЭВГАНДИ



0000197



**“ЧАДВАРЛАГ БАГШ, СУРАГЧ, ОЮУТАН”  
ДЭД ХӨТӨЛБӨР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж, Боловсрол, шинжлэх ухааны яам хөтөлбөр, төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9-д “Чадварлаг багш, сурагч, оюутан” дэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгасан.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өсвөр үеийнхнийг өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах чадвартай, оюун сэтгэхүй, ёс суртахууны төлөвшилтэй хувь хүн болж хөгжихөд эцэг эх, төрийн үүрэг, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, багш, суралцагчдыг бүх талаар хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.11, 2.3.18, 2.3.21, 2.3.23, 2.3.27, 2.3.30 заасан арга хэмжээг хэрэгжүүлэх суурь болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

**2.1. Хөтөлбөрийн зорилго**

Багш, оюутан, сурагчдыг дэмжих, урамшуулах, хөгжүүлэх замаар нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

**2.2. Хөтөлбөрийн зорилт**

1. Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн баталгааг сайжруулах;
2. Сурагчдын авьяас, чадвар, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, сургалтын орчны нөхцөлийг сайжруулах;

3. Орон нутагт нэн хэрэгцээт мэргэжлээр суралцах чадварлаг оюутныг бэлтгэж, дэмжих;

**2.3. Хөтөлбөрийн хугацаа**

2.3.1. Хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2021-2024 онд хэрэгжүүлнэ.



Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хангах арга хэмжээ, үйл ажиллагааны чиглэл

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.1. Орон нутгийн түвшинд багшийн тасралтгүй хөгжлийг хангаж эрх зүйн орчныг бүрдүүлж "Ховдын багш" загварыг бий болгох,

3.1.2. "Чадварлаг багш нарыг дэмжих, урамшуулах" журам хэрэгжүүлэх

3.1.3. Багшийг хөгжүүлэх орчныг бүрдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах;

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.1. Бид Ховдын хүүхдүүд аян зохион байгуулах;

3.2.2. Гадаад, дотоодын болон орон нутгийн өмчит амралтын газруудыг түшиглэн зуны сургалт зохион байгуулах, сурагчдын сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжих;

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3.1. Дунд, ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах;

3.3.2. "Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховдын ирээдүй" тэтгэлэг олгох журам хэрэгжүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

4.1. Багшийн ажиллах, суралцах, хөгжих таатай орчин бүх сургууль, цэцэрлэгт бүрдэж, аймаг, бүс, улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд амжилт гаргасан багш нарын тоо нэмэгдэж "Ховдын багш" загвар бий болсон байна.

4.2. Сурагчдын сурах арга барилд өөрчлөлт гарч, бүтээлч сэтгэлгээ хөгжиж аймаг, бүс, улсад амжилт гаргах сурагчдын тоо нэмэгдэж, сурагчид хамтран хөгждөг болно.

4.3. Багш, мэргэжлээр суралцах хүсэл тэмүүлэлтэй, их дээд сургуульд өндөр оноотой элсэгч сурагчдын тоо нэмэгдэж, орон нутгийн тэтгэлгээр суралцдаг оюутны тоо нэмэгдэнэ.

д/д	Хэрэгжүүлэх ажиллагаа	үйл	Шалгуур	Суурь түвшин	Үр дүнгийн үзүүлэлт Хүрсэн төвшин				Төсөв /сая төгрөгөөр/
					2021	2022	2023	2024	
Хөтөлбөрийн 1-р зорилт Багшийн хөгжил, хандлага, хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллах, суралцах, хөгжих, сургах, судлах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх:									
1	"Чадварлаг багш" баруун бүсийн эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах	Эрдэм шинжилгээний хуралд оролцсон илтгэлийн тоо		0		45	45	10	

2	Залуу багш нарын чуулга, уулзалт зохион байгуулах	Чуулга, уулзалтад оролцсон залуу багшийн тоо	0		150		150	20
3	Ахмад багш нарын зөвлөгөөн зохион байгуулах	Ахмад багш нарын чуулганд оролцогчдын тоо	0		250			4
4	Боловсролын тусгай хэрэгцээт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй сургалт зохион байгуулах	Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтад хамрагдсан багшийн тоо	2		10	10	10	6
5	Багш солилцох үйл ажиллагааг зохион байгуулах	Багш солилцооны хөтөлбөрт хамрагдсан багш нарын тоо	45		75	75	75	15
6	Жилд 10 багшийг гадаадад, 20 багшийг дотоодод туршлага судлах	Гадаад болон дотоодод туршлага судлах багшид зарцуулсан зардлын хэмжээ	0		15	15	15	45
7	Ховд их сургуулийн дэргэд "Нээлттэй боловсролын төв"-ажиллуулах	"Нээлттэй боловсрол" төвөөр үйлчлүүлсэн багшийн тоо	0	50	150	250	300	4
8	"Чадварлаг багш нарыг дэмжих, урамшуулах" журам хэрэгжүүлэх	Чадварлаг багшийн тоо, шагналын зардлын хэмжээ	0	120	120	120	120	480
9	Багш нарыг компьютержуулах	Шинээр компьютер олгосон багш нарын тоо	950		500	500	500	3200
10	Багш нарыг орон сууцжуулахад дэмжлэг үзүүлэх	Орон сууцаар хангагдсан багш нарын тоо	0		100	100	100	80
11	Багшийн хөгжлийн цахим платформ бий болгох	Платформ ашиглан хөгжсөн багшийн тоо	0		500	500	500	70
Хөтөлбөрийн 2-р зорилт. Сурагчдын авьяас, сурах арга барил, ур чадварыг хөгжүүлэх:								
12	Бид Ховдын хүүхдүүд аян зохион байгуулах	Аяны хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний тоо	5	6	6	6	6	6
13	"Алтан өв" сайн дурын сурагч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдсан сурагчдын тоо	0		2		2	4
14	"Хүүхэд бүрээ хөгжүүлэгч сургууль" фестиваль зохион байгуулах	Фестивальд оролцсон сургуулийн тоо, хамрагдсан сурагчдын тоо	0				5	5
15	Оюунлаг, авьяаслаг, спортлог сурагчдын "Миний амжилтын түүх" хөрөг нэвтрүүлэг хийх	Нэвтрүүлгийн тоо, нэвтрүүлэгт оролцсон сурагчдын тоо	0	1	1	1	1	4



16	Сурагчдын сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжих;	Сурагчдын сайн дурын үүсгэл санаачилгын байгууллагуудын тоо	0	150	150	150	12
17	Гадаад, дотоодын болон орон нутгийн өмчит амралтын газруудыг түшиглэн зуны сургалт зохион байгуулах	Зуны сургалтад хамрагдсан сурагчдын тоо	0	150	150	150	12
Хөтөлбөрийн 3-р зорилт. Чадварлаг оюутныг бэлтгэх, хөгжүүлэх:							
18	Багш сонгоны бүлэг хичээллүүлэх	Багш сонгоны бүлэгт хамрагдсан сурагчдын тоо	0	25	25	25	4
19	Аймгийн Засаг даргын нэрэмжит "Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховдын ирээдүй" журам боловсруулан хэрэгжүүлнэ	Тэтгэлэг, урамшуулал авсан сурагчдын тоо	0	20	20	20	200
НИЙТ ТӨСӨВ							4,186.0

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Улсын төсөв.

5.2. Орон нутгийн төсөв.

5.3. Олон улсын төсөл, хөтөлбөр.

5.4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив

5.5. Бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг жил бүрийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх, төр болон төрийн бус байгууллагуудын оролцоо уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахыг Боловсролын газар, хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүжилтийн асуудлыг аймгийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь сургалт, хүүхэд нэг бүрийг хөгжүүлж буй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа байх бөгөөд сургалтыг ажлын байрны, бүсчилсэн болон зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг цэцэрлэг, сургууль бүр жилийн төлөвлөгөөндөө тусган Боловсролын газарт тайлагнан ажиллана.

Долоо. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийг биелэлтээр гарган Боловсролын газарт жил бүр тайлагнана

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор 2 жил тутам хийх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулж, зөвлөмж гаргана.

Найм. Хамрах хүрээ:

8.1. Багш сурган хүмүүжүүлэгчид, мэргэжилтэн, албан хаагчид

8.2. Хүүхэд багачууд, оюутан суралцагчид

---oOo---

**"ЧАДВАРЛАГ БАГШ, СУРАГЧ, ОЮУТАН" ДЭД  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**


д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хугацаа				Хамрах хүрээ	Хариуцах эзэн	Төсөв /сая төгрөгөөр/	Төсвийн эх үүсвэр
				2021	2022	2023	2024				
Хөтөлбөрийн 1 дүгээр зорилт. Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн баталгааг сайжруулах:									3934		
1	3.1.1. Орон нутгийн төвшинд багшийн тасралтгүй хөгжлийг хангаж эрх зүйн орчныг бүрдүүлж "Ховдын багш" загварыг бий болгоно.	"Чадварлаг багш" баруун бүсийн эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулна	Баруун бүсийн боловсролын салбарын тулгамдсан асуудлуудыг үе шаттай шийдвэрлэх гарц бий болсон байна.		+	+		Баруун бүсийн аймаг	ЗДТГ, БГ, ХИС	10	Орон нутгийн төсөв
2		Залуу багш нарын чуулга, уулзалт зохион байгуулна	Залуу багш нарын сайн дурын байгууллагын үйл ажиллагаа идэвхэжсэн байна.		+		+	Залуу багш нар	БГ, Залуу багш нарын холбоо	20	Орон нутгийн төсөв
3		Ахмад багш нарын аймаг, бүсийн зөвлөгөөн зохион байгуулна	Ахмад багш нарын чуулган зохион байгуулагдсан байна		+			Ахмад багш нар	ЗДТГ, БГ, "Эрдмийн оргил" холбоо	4	Орон нутгийн төсөв
4		Боловсролын тусгай хэрэгцээт болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэнэ	Сургууль бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэгдэнэ.		+	+	+	Боловсролын салбар	БГ, ГЕХЗХГ, Төсөл хөтөлбөр	6	Орон нутгийн төсөв
5		Багш солилцох үйл ажиллагааг зохион байгуулна	Их сургууль, коллеж, ебс, сөб-ийн багш нарын хамтын ажиллагаа өргөжиж, ажлын байраа сэлгэн ажилласан багш нарын тоо нэмэгдсэн байна.		+	+	+	Боловсролын салбар	БГ, ХИС	15	Улсын төсөв

6		Жилд 10 багшийг гадаадад, 20 багшийг дотоодод туршлага судлуулна	Багш нарын бүтээлч сэтгэлгээ дэмжигдэн сайн туршлага бий болно		15	15	15	ЕБС	ЗДТГ, БГ	45	Орон нутгийн төсөв
7		Ховд их сургуулийн дэргэд "Нээлттэй боловсролын төв"-ийг ажиллуулна	Ховд их сургууль нийгмийн хариуцлагын хүрээнд төгсөгчдөө давтан сургаж, чадваржуулсан байна.	1	1	1	1	СӨБ, ЕБС	БГ, ХИС	4	Төсөл, хөтөлбөр
8	3.1.2. "Чадварлаг багш нарыг дэмжих, урамшуулах" журам хэрэгжүүлэх;	"Чадварлаг багш нарыг дэмжих, урамшуулах" журам хэрэгжүүлэх	Багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, амжилт, туршлага түгээгдсэн байна.	120	120	120	120	ЕБС, цэцэрлэг, Коллеж, ИХ сургууль	ЗДТГ, БГ, Аж ахуйн нэгж	480	Орон нутгийн төсөв
9		Багш нарыг компьютержуулна	Багш нар компьютероор бүрэн хангагдсан байна.	800	800	800	800	ЕБС, цэцэрлэг, Коллеж	БШУ-ны яам, ЗДТГ	3200	Улсын төсөв
10	3.1.3. Багшийг хөгжүүлэх орчныг бүрдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах	Багш нарыг орон сууцжуулахад дэмжлэг үзүүлнэ	Аймгийн төвд багш нарын хотхон, өндөр ур чадвар бүхий багш, мэргэжилтэн шаардлагатай сумдад "4 айлын жишиг сууц" баригдсан байна.	20	20	20	20	Нийгмийн салбар	Аймаг сумын ЗДТГ, Төсөл хөтөлбөр	80	Орон нутгийн төсөв
11		Багшийн хөгжлийн цахим платформ бий болгоно	Багш сурагчдын цахим хөгжлийг хангах орон нутгийн вэб сервер, цахим технологийн цогц системтэй болсон байна.	60	5	5		ЕБС, Цэцэрлэг	ЗДТГ, БГ, Төсөл хөтөлбөр	70	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр
Хөтөлбөрийн 2 дугаар зорилт. Сурагчдын авьяас, чадвар бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, сургалтын орчны нөхцөлийг сайжруулах;										48	
12	3.2.1. Бид Ховдын хүүхдүүд аян зохион байгуулах;	Бид ховдын хүүхдүүд аян зохион байгуулна	сурагчдын өв соёлоо дээдлэх, амьдрах арга ухааны чадварт ахиц гарсан байна.		1.5	1.5	1.5	ЕБС	БГ ЕБС	6	Орон нутгийн төсөв



13		"Алтан өв" сайн дурын сурагч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	Олон үндэстний өв соёлоос харилцан суралцана.		2		2	ЕБС, Цэцэрлэг	БГ СӨБ, ЕБС	4	Орон нутгийн төсөв
14		Хүүхэд бүрээ хөгжүүлэгч сургууль фестиваль зохион байгуулна	Хүүхэд нэг бүр хөгжсөн байна.				5	ЕБС	БГ	5	Орон нутгийн төсөв
15		Оюунлаг, авьяаслаг, спортлог сурагчдын "Миний амжилтын түүх" хөргө нэвтрүүлэг хийнэ	Суралцах, хөгжих хүсэл эрмэлзэл, мөргөөдөлтэй болсон байна.	1	1	1	1	ЕБС	БГ	4	Орон нутгийн төсөв
16	3.2.2. Гадаад, дотоодын болон орон нутгийн өмчит амралтын газруудыг түшиглэн зуны сургалт зохион байгуулах.	Сурагчдын үүсгэл санаачилгыг дэмжинэ	Сурагчид гадаад хэлээр харилцах чадварт ахиц гарч, даян дэлхийн хэмжээнд хамтран суралцсан байна.	3	3	3	3	Их сургууль, Коллежи, ЕБС	БГ ГБХЗГ	12	Орон нутгийн төсөв
17	сурагчдын сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжих;	Зуны сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ	Зуны сургалтад оролцогч сурагчдын тоо нэмэгдсэн байна.	3	3	3	3	Их сургууль, Коллежи, ЕБС	БГ ГБХЗГ	12	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр
Хөтөлбөрийн 3 дугаар зорилт. Орон нутагт нэн хэрэгцээт мэргэжлээр суралцах чадварлаг оюутныг бэлтгэж, дэмжих:										204	
18	3.3.1. Дунд, ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах;	Багш сонгоны бүлэг хичээллүүлнэ	Багш мэргэжил сонгох сурагчдын тоо нэмэгдэж, эрэлт бүхий багш мэргэжлээр элсэгчдийн тоо нэмэгдсэн байна.	1	1	1	1	ЕБС, Цэцэрлэг	БГ	4	Орон нутгийн төсөв

19	3.3.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит "Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховдын ирээдүй" тэтгэлэг олгох журам хэрэгжүүлэх;	Тэтгэлэг олгох, шагнах урамшуулах журам боловсруулж хэрэгжүүлнэ	Чадварлаг оюутнуудыг их дээд сургуульд бэлтгэсэн байна.	50	50	50	50	ЕБС, Цэцэрлэг	ЗДТГ	200	Орон нутгийн төсөв
Нийт санхүүжилт										4,186.00	



ЧАДВАРЛАГ БАГШ НАРЫГ ДЭМЖИХ,  
УРАМШУУЛАХ ЖУРАМ

Зорилго:

Ховд аймгийн хөгжлийн суурь үндэс болсон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, ирээдүй хойч үеийг хөгжүүлэхэд манлайлан ажиллаж байгаа багш нарыг алдаршуулах, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд оршино.

Нэг. “Чадварлаг багш”-ийг шалгаруулах:

1.1. Сурган хүмүүжүүлэх ажлаараа багш нараа манлайлан, орон нутгийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэх үйлсэд иргэд, олон нийтийг үлгэрлэн ажиллаж байгаа багш нарыг “Чадварлаг багш”-аар шалгаруулан Багш нарын өдрөөр шагнаж алдаршуулна.

1.2. “Чадварлаг багш”-ийн шалгуур үзүүлэлт:

1.2.1. Ховд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн их сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгт үндсэн багш;

1.2.2. Боловсролын чанарыг сайжруулах сургалт, хөгжлийн арга зүй, технологийг туршин хэрэгжүүлж нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн;

1.2.3. Орон нутгийн болон боловсролын байгууллагын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд санаачилга гарган нийгэм хамт олны дунд амьдралын зэрэг хандлага бий болгоход манлайлан ажилласан;

1.2.4. Удирдсан болон хичээл заадаг ангийн хүүхэд бүрийг хөгжүүлсэн байдал, сүүлийн 3 жилийн сурлагын амжилт нь аймагтаа тэргүүлсэн;

1.2.5. Улс, аймаг, сумаас зохион байгуулсан боловсролын чанарын үнэлгээ, төвшин тогтоох шалгалтаар заадаг хичээлээрээ амжилт гаргасан;

1.2.6. Багшлах хугацаандаа төрийн албаны болон багшийн ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй;

1.2.7. Тухайн сургалтын байгууллагадаа тогтвор суурьшилтай 5-аас дээш жил ажилласан;

1.3. Шалгаруулалт:

1.3.1. Шалгаруулалтыг жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг тухайн хичээлийн жилийн 9 дүгээр сард зохион байгуулна



1.3.2. Сургалтын байгууллага бүр чадварлаг багшаа шалгаруулан сургууль, цэцэрлэгийн зөвлөлөөр хэлэлцүүлж сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын салбар тус бүрээс 1 “Чадварлаг багш”-ийг шалгаруулж, олон нийтийн хэлэлцүүлгийн тогтоолын хамт 09 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Боловсролын газарт ирүүлнэ.

1.3.3. Ажлын хэсэг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж, салбар бүрээс нэгээс доошгүй багшийг шалгаруулж, “Чадварлаг багш” өргөмжлөл, 10.0 сая хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулна.

1.4. Сумын Засаг дарга жил бүр сумынхаа хүрээнд “Чадварлаг багш”-ийг шалгаруулж, “Багш нарын өдөр”-ийг тохиолдуулан шагнаж, урамшуулна.

Хоёр: Улсын хэмжээнд зохион байгуулсан боловсролын салбарын уралдаан, тэмцээн, нэгдсэн шалгалт, үнэлгээнд амжилт үзүүлсэн сургууль, багш нарыг шагнаж урамшуулах шалгуур:

2.1. Улсын хэмжээнд хичээл, судлагдахуунаар зохион байгуулсан анги нийтийн уралдаанд бэлтгэсэн шавь нар нь ангиараа (20-оос дээш сурагч) амжилттай оролцож

- Улсад 1 дүгээр байрт шалгарсан бол хичээл заасан багшийг 1.0 сая төгрөгөөр;

- Улсад 2 дугаар байрт шалгарсан бол 800.0 мянган төгрөгөөр;

- Улсад 3 дугаар байрт шалгарсан бол 500.0 мянган төгрөгөөр;

Хэрэв багшийн 2 ба түүнээс дээш анги нь улсад амжилттай оролцож байр эзэлсэн бол хамгийн эхний байраар тооцно.

2.2. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан чанарын үнэлгээ, судалгаа, аймаг, сумын ИТХ, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан шалгалт, үнэлгээгээр амжилт гаргаж заасан анги нь:

А. Улсад:

- 1 дүгээр байр эзэлсэн бол 3.0 сая төгрөгөөр;

- 2 дугаар байр эзэлсэн бол 2.0 сая төгрөгөөр;

- 3 дугаар байр эзэлсэн бол 1.0 сая төгрөгөөр;

Б. Аймагт:

- 1 дүгээр байр эзэлж, улсын дунджаас давсан бол 1.0 сая төгрөг;

- 2 дугаар байр эзэлж улсын дунджаас давсан бол 800.0 мянган төгрөг;

- 3 дугаар байр эзэлж, улсын дунджаас давсан бол 500.0 мянган төгрөгөөр;

В. Суманд:

- 1 дүгээр байр эзэлж, аймгийн дунджаас давсан бол 500.0 мянган төгрөгөөр;

- 2 дугаар байр эзэлж, аймгийн дунджаас давсан бол 300.0 мянган төгрөгөөр;

- 3 дугаар байр эзэлж, аймгийн дунджаас давсан бол 200.0 мянган төгрөгөөр болон цалингийн 20 хүртэл хувиар шагнаж урамшуулна.

2.3. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан элсэлтийн шалгалтын амжилтыг үнэлэн сургууль, багш нарыг дараах шалгуураар шагнаж, урамшуулна

- Бэлтгэсэн шавь нь 800 оноо авсан бол нэг сая төгрөг;

- Боловсролын газрын судлагдахуун хариуцсан мэргэжилтний хариуцсан хичээлийн элсэлтийн шалгалтын дундаж оноо нь

- улсад 1 дүгээр байр эзэлсэн бол 1.0 сая төгрөгөөр;

- 2 дугаар байр эзэлсэн бол-800.0 мянган төгрөгөөр;

- 3 дугаар байр эзэлсэн бол 500.0 мянган төгрөгөөр шагнана.

- Боловсролын үнэлгээний төвөөс гаргасан элсэлтийн ерөнхий шалгалтын хичээл бүрийн дундаж оноо, 12 дугаар ангийн төгсөгчдийн элсэлтийн шалгалтад хамрагдсан хувиар харгалзан тооцож эзлүүлсэн жагсаалтаар аймгийн хэмжээнд:

- тэргүүлсэн сургуулийг 10.0 сая төгрөгөөр;

- 2 дугаар байр эзэлсэн бол 8.0 сая төгрөгөөр;

- 3 дугаар байрт шалгарсан бол 5.0 сая төгрөгөөр шагнах ба шагналыг тухайн сургууль, багшийн хөгжилд 30 хувь, шагнал урамшуулалд -70 хувийг зарцуулна.

2.4. Багш, сурагч, оюутан олон улсын болон улсын чанартай мэргэжлийн олимпиад, ур чадварын уралдаанд амжилттай оролцож:

- Сурагч алтан медаль авсан бол 5.0 сая төгрөгөөр;

- Сурагч мөнгөн медаль авсан бол 3.0 сая төгрөгөөр;

- Сурагч хүрэл медаль авсан бол 1.0 сая төгрөгөөр;

- Багш алтан медаль авсан бол 5.0 сая хүртэл төгрөгөөр;

- Багш мөнгөн медаль авсан бол 3.0 сая хүртэл төгрөгөөр;

- Багш хүрэл медаль авсан бол 2.0 сая хүртэл төгрөгөөр;

- Бэлтгэсэн шавь нь медаль авсан бол удирдсан, хичээл заасан багшийг 2.0 сая төгрөгөөр шагнана.

2.5. Төрийн болон төрийн бус байгууллагаас улсын хэмжээнд зохион байгуулж, улсын нийт сургуулийн 50-аас дээш хувь оролцсон тохиолдолд түүнийг “улсын хэмжээний уралдаан тэмцээн” гэж тооцно.

Гурав. Журмын санхүүжилт

3.1. Улсын төсөв болон аймаг, сумын орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлнэ.



“ЧАДВАРЛАГ МЭРГЭЖИЛТЭН-ШИНЭ ХОВДЫН ИРЭЭДҮЙ”  
ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Тэтгэлэг олгох үндэслэл

1.1. Ховд аймгийн хөгжлийн суурь үндэс болсон боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх, орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх, оюутан, суралцагчдын нийгмийн баталгааг дэмжих, эрдэм шинжилгээ судалгааны амжилтыг урамшуулах зорилгоор их дээд сургуульд элсэн суралцаж байгаа Ховд аймгийн харьяат оюутан, суралцагчдад тэтгэлэг олгоход энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Тэтгэлэгт дэвшүүлэх, сонгох

2.1. Тэтгэлэгт дэвшигч эрдэм шинжилгээ, сурлага, урлаг спортын амжилтаараа салбар, хамт олноо манлайлагч байх бөгөөд дараах нөхцөлийг хангасан оюутан, суралцагчдад тэтгэлэг олгоно.

2.2. Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан эрэлттэй мэргэжлээр суралцаж буй 10 хүртэлх хүүхдийн сургалтын төлбөрийг орон нутгаас хариуцна.

2.3. Ховд аймгийн хэмжээнд эрэлт хэрэгцээтэй болон математик, физик, химийн багш, эмч, инженер, малын эмч мэргэжлээр Ховд Их сургууль, МУИС, ШУТИС, МУБИС, ХААИС, АШУҮИС-д элсэн суралцаж байгаа оюутан, суралцагч байна. Үүнд:

2.3.1. Нэгдүгээр ангийн оюутан нь элсэлтийн ерөнхий шалгалтад 750-аас дээш оноо авсан элсэн суралцагч байна.

2.3.2. Хоёр, гурав, дөрөвдүгээр ангийн оюутан нь улирал бүр В буюу 3.5-аас доошгүй голч оноотой суралцсан байна.

2.3.3. Тодорхой сэдвийн хүрээнд улсын төсөлт болон гэрээт эрдэм шинжилгээний ажил, судалгааны экспедицид оролцдог байна.

2.3.4. Урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээнд манлайлагч байна.

2.3.5. Зохион бүтээсэн багаж, тоног төхөөрөмж, эрдэм шинжилгээний илтгэл нь инновацад суурилсан, сургууль болон дээд шатны уралдаанд шалгарсан байна.

2.3.6. Энэхүү журмын 2.3.2-2.3.5 дахь заалтыг хангасан оюутан болохыг сургуулийн захиргаа, хамт олон батлан тодорхойлсон байна.



2.3.7. Тэтгэлэгт хамрагдсан оюутан, суралцагчидтай аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газраас гэрээ хийж, гэрээнд орон нутагт шаардлагатай ажлын байранд 5-аас доошгүй жил тасралтгүй ажиллах нөхцөлийг тусгаж, хэрэгжилтийг хангуулан ажиллана.

2.4. Ерөнхий эрдмийн хичээл тус бүрд элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай оролцож 800 оноо авч, аймагт тэргүүлсэн суралцагчдад 1.0 сая төгрөг, 780-аас дээш оноо авч аймагт тэргүүлсэн суралцагчдад 500.0 мянган төгрөг, 750-аас дээш оноо авсан суралцагчдад 300.0 мянган төгрөгийн урамшуулал тус тус олгоно.

2.5. Урамшууллыг давхардуулж олгохгүй.

2.6. Аймгийн хэмжээнд эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас жил бүр гаргана.

Гурав. Бүрдүүлэх бичиг баримт:

3.1 .Тэтгэлэгт хамрагдах суралцагч нь дараах баримт бичгийг бүрдүүлэн аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт жил бүрийн 1, 6 дугаар сарын 15-ны дотор ирүүлсэн байна.

3.1.1. Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж (шинээр элсэгч);

3.1.2. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас олгосон суралцах эрхийн бичиг (шинээр элсэгч);

3.1.3. Товч намтар.

3.1.4. Оюутан суралцагч нь энэхүү журмын 2.3.6-д заасны дагуу тодорхойлолтыг сургалтын алба, сургуулийн захирлаар баталгаажуулж ирүүлнэ.

Дөрөв. Тэтгэлгийн санхүүжилт:

4.1. Оюутан, суралцагчдад тэтгэлгийг хагас, бүтэн жилд тус бүр 1.0 сая төгрөг хүртэл урамшууллыг гэрээгээр олгоно.

4.2. Оюутан, суралцагчдад олгох тэтгэлгийн зардлыг тухайн жилийн аймгийн төсөвт тусгаж, тэтгэлэгт хамрагдах оюутны тоог хичээлийн жилийн эхэнд жил бүр шинэчлэн тогтооно.

4.3. Тэтгэлэг хүртэгч нь бакалаврын боловсрол эзэмших өдрийн ангид болон нарийн мэргэжлээр суралцаж буй энэхүү журмын 2.2, 2.3, 2.4 дэх заалтыг хангасан оюутан, суралцагч байна.

Тав. Тэтгэлэг олгох, зогсоох.

5.1. Тэтгэлэг олгох оюутны нэрийг тухайн сургуулийн захирлын хүсэлтийг үндэслэн дэвшүүлнэ.

5.2. Нэр дэвшүүлэх талаар сургуулийн захиргааны зөвлөлөөр хэлэлцсэн хурлын тэмдэглэл байна.

5.3. Нэр дэвшигчдэд тэтгэлэг олгох асуудлыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргаж, Засаг даргын захирамжаар тэтгэлэг, гэрчилгээг олгоно.

5.4. Тэтгэлэг авч байгаа оюутан, суралцагчийн сурлагын амжилт буурсан тохиолдолд дараагийн улирлаас эхлэн болзлоос хасагдана.

5.5. Тэтгэлэг авч байгаа оюутан, суралцагч хууль эрх, нийгмийн хэв журмын ноцтой зөрчил гаргасан, эрдэм шинжилгээний ажилд оролцохоо больсон, ямар нэг шалтгаанаар сургуулиас хасагдсан, завсардсан тохиолдолд сургуулийн дүгнэлтийг үндэслэн Засаг даргын захирамжаар уг тэтгэлгийг зогсоож буцаан төлүүлнэ.

---oOo---